



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/46/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn</p> <p>Аудитор П.Цэцэгдулам Цахим хаяг: Tsetsegdulamp@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	1
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

᠒᠐᠒᠒.᠐᠔.᠒᠖ № ᠒4
танай _____-ны № _____-т

БУЛГАН СУМЫН СОЁЛЫН
ТӨВИЙН ДАРГА П.ОЮУНЧИМЭГ
ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,050,800.00	4,995,479.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,050,800.00	4,995,479.00
35400	Хангамжийн материал	4,050,800.00	4,995,479.00
35420	Аж ахуйн материал	4,050,800.00	4,995,479.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	24,281,128.80	23,291,955.58
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	24,281,128.80	23,291,955.58
39200	Биет хөрөнгө	20,345,128.80	19,355,955.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,234,780.00	4,234,780.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-4,234,780.00	-4,234,780.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	12,506,027.00	12,506,027.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-7,425,659.00	-8,260,384.92
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,261,647.00	4,261,647.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,202,465.20	-3,356,912.50
39217	Ном	14,205,579.00	14,205,579.00
39300	Биет бус хөрөнгө	3,936,000.00	3,936,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	3,936,000.00	3,936,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	28,331,928.80	28,287,434.58
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	28,331,928.80	28,287,434.58
51	Засгийн газрын хувь оролцоо	28,331,928.80	28,287,434.58
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	25,447,892.00	25,447,892.00
51200	Хуримтлагдсан үр дүн	2,884,036.80	2,839,542.58
51210	Өмнөх үеийн үр дүн	2,884,036.80	2,884,036.80
51220	Тайлант үеийн үр дүн		-44,494.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	28,331,928.80	28,287,434.58

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	74,886,710.00	172,234,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,241,010.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,241,010.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,241,010.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	0.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,741,010.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	70,645,700.00	172,234,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	70,645,700.00	172,234,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	70,645,700.00	172,234,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	69,834,905.25	77,520,735.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	69,834,905.25	77,520,735.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	68,034,905.25	76,945,194.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	54,056,500.00	58,056,500.00
210101	Үндсэн цалин	54,056,500.00	58,056,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,297,600.00	7,837,600.00
210201	Тэтгэврийн даатгал	5,135,400.00	5,515,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	540,500.00	580,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	432,500.00	464,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	108,100.00	116,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,081,100.00	1,161,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,600,000.00	7,600,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,500,000.00	208,133.00
210302	Түлш, халаалт	4,000,000.00	7,291,867.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	523,500.00	573,100.00
210401	Бичиг хэрэг	66,500.00	184,670.00
210402	Тээвэр, шатахуун	202,000.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00	0.00
210404	Ном, хэвлэл	66,300.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	118,700.00	128,430.00
2105	Нормативт зардал	49,600.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,600.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.00	100,000.00
210604	Урсгал засвар	100,000.00	100,000.00
2107	Томилолт, зочны зардал	70,500.00	70,500.00

210702	Дотоод албан томилолт	70,500.00	70,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	308,642.00	1,718,321.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,000.00	1,632,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000.00	80,000.00
210807	Газрын төлбөр	78,642.00	5,821.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,563.25	989,173.22
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,563.25	989,173.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,800,000.00	575,541.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,800,000.00	423,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800,000.00	423,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	151,741.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	151,741.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	5,051,804.75	94,713,764.78
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	94,758,259.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0.00	94,758,259.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	5,051,804.75	-44,494.22

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	25,447,892.00	0.00	2,884,036.80	28,331,928.80
2	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	25,447,892.00	0.00	2,884,036.80	28,331,928.80
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	25,447,892.00	0.00	2,884,036.80	28,331,928.80
4	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-44,494.22	-44,494.22
5	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	25,447,892.00	0.00	2,839,542.58	28,287,434.58

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	72,145,700.00	172,234,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,500,000.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,500,000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,500,000.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	70,645,700.00	172,234,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	70,645,700.00	172,234,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	70,645,700.00	172,234,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	69,806,342.00	77,476,241.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	69,806,342.00	77,476,241.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	68,006,342.00	76,885,700.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	54,056,500.00	58,056,500.00
210101	Үндсэн цалин	54,056,500.00	58,056,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,297,600.00	7,837,600.00
210201	Тэтгэврийн даатгал	5,135,400.00	5,515,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	540,500.00	580,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	432,500.00	464,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	108,100.00	116,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,081,100.00	1,161,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,600,000.00	7,600,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,500,000.00	1,500,000.00
210302	Түлш, халаалт	4,000,000.00	6,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	524,100.00	524,100.00
210401	Бичиг хэрэг	66,500.00	66,500.00
210402	Тээвэр, шатахуун	202,000.00	202,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00	70,000.00
210404	Ном, хэвлэл	66,300.00	66,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	119,300.00	119,300.00
2105	Нормативт зардал	49,000.00	49,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,000.00	49,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.00	100,000.00
210604	Урсгал засвар	100,000.00	100,000.00
2107	Томиллолт, зочны зардал	70,500.00	70,500.00
210702	Дотоод албан томиллолт	70,500.00	70,500.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	308,642.00	2,648,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,000.00	2,422,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000.00	80,000.00
210807	Газрын төлбөр	78,642.00	145,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,800,000.00	590,541.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,800,000.00	438,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800,000.00	438,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	151,741.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	151,741.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,339,358.00	94,758,259.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,339,358.00	94,758,259.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,339,358.00	94,758,259.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,339,358.00	94,758,259.00
220001	Барилга байгууламж	0.00	94,758,259.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,339,358.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,339,358.00	-94,758,259.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	172,234,500.00	172,082,759.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	77,324,500.00	77,324,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	76,885,700.00	76,885,700.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	58,056,500.00	58,056,500.00
210101	Үндсэн цалин	58,056,500.00	58,056,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,837,600.00	7,837,600.00
210201	Тэтгэврийн даатгал	5,515,400.00	5,515,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	580,500.00	580,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	464,500.00	464,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	116,100.00	116,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,161,100.00	1,161,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,600,000.00	7,600,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,500,000.00	1,500,000.00
210302	Түлш, халаалт	6,000,000.00	6,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	524,100.00	524,100.00
210401	Бичиг хэрэг	66,500.00	66,500.00
210402	Тээвэр, шатахуун	202,000.00	202,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00	70,000.00
210404	Ном, хэвлэл	66,300.00	66,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	119,300.00	119,300.00
2105	Нормативт зардал	49,000.00	49,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	0.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,000.00	49,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.00	100,000.00
210604	Урсгал засвар	100,000.00	100,000.00
2107	Томилолт, зочны зардал	70,500.00	70,500.00
210702	Дотоод албан томилолт	70,500.00	70,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,648,000.00	2,648,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,422,500.00	2,422,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000.00	80,000.00
210807	Газрын төлбөр	145,500.00	145,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	438,800.00	438,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	438,800.00	438,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	438,800.00	438,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	94,910,000.00	94,758,259.00
220001	Барилга байгууламж	94,910,000.00	94,758,259.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	172,234,500.00	172,082,759.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	0.00	0.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	172,234,500.00	172,082,759.00
320001	Орон нутгийн төсвөөс	172,234,500.00	172,082,759.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6	6
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	3	3
620003	Үйлчлэх ажилтан	2	2

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Цэцэгдулам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Булган сумын Соёлын төв нь соёлын үйлчилгээг хөдөөгийн хүн амд хүргэн соёлын үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж, үндэсний болон орчин үеийн соёл урлагийн үйл ажиллагааг ард иргэд, хүүхэд багачуудад зааж сургах, түгээн дэлгэрүүлэх чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харьяа орон нутгийн төсвийн байгууллага байна.

Тус байгууллага нь тайлант онд “*Орон нутагт байгаа түүх соёлын үл хөдлөх дурсгалт газруудын тоог нэмэгдүүлэх, шинээр бүртгэн баримтжуулах Соёлын өвийн тухай хуулийг иргэдэд сурталчилах*” зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Соёлын тухай хууль
- “Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-иар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Булган сумын Соёлын төвийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэль сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 172.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 1.2 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 0.1 сая төгрөгөөр буюу 0.4 хувиар буурсан материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	хувь
Бараа материал	4.0	4.9	0.9	22.5
Үндсэн хөрөнгө	24.3	23.3	(1.0)	(4.1)
Нийт хөрөнгө	28.3	28.2	(0.1)	(0.4)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	28.3	28.2	(0.1)	(0.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	28.3	28.2	(0.1)	(0.4)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материал эхний үлдэгдлээс 22.5 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 4.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 9.2 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 8.3 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст 4.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 4.1 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 24.3 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант хугацаанд байгуулсан 1.0 сая төгрөгийн элэгдэлийн зардлаар буурч 23.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 0.04 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	70.6	172.2	101.6
Үндсэн үйл ажиллагааны орлого	1.5	0	-1.5
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2.7	0.0	-2.7
Үйл ажиллагааны орлого	74.8	172.2	97.4
Цалин, шимтгэлийн зардал	61.3	65.9	4.6
Бараа ажил үйлчилгээний зардал	6.3	8.1	1.8
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.3	1.7	1.4
Бараа үйлчилгээний бусад зардал	0.0	1.0	1.0
Урсгал шилжүүлэг	1.8	0.6	-1.2
Хөрөнгийн зардал	-	94.7	94.7
Үйл ажиллагааны зардал	69.7	172.0	102.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-18.60	5.30	23.9

Булган сумын Соёлын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 101.6 сая төгрөг өссөн нь тайлант онд хөрөнгийн зардал нэмэгдсэнтэй холбоотой байна. Санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 79.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 2.2 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 77.3 сая төгрөгөөр хянаж баталсан бол тодотголоор 172.2 сая төгрөг буюу 94.9 сая төгрөгийн хөрөнгийн зардлаар нэмэгдүүлэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 172.2 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, 172.0 сая төгрөгийг зарцуулж, 0.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Булган сумын Соёлын төв нь 2021 онд Ковид-19 цар тахлын үеийн дэглэм, улс, аймаг, сумын онцгой комиссоос гаргасан соёл урлагийн үйлчилгээг хориглосон шийдвэрийн улмаас олон нийтийг хамарсан үйл ажиллагааг зохион байгуулаагүй, өөрийн орлогын төлөвлөгөө батлуулаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 7 үндсэн зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 92.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 172.2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 99.9 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэлэхэд Үүнд:

- Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд цалин хөлс, албан конторын тавилга, шагнал, албан томилолт, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
- Тус байгууллага нь өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгсэлгүй бөгөөд албан ажлаар явах зайлшгүй шаардлагатай тохиолдолд албан ажлаар явахдаа бусад байгууллага болон хувь унаанд шатахуунаа хийж явдаг байна.

Харин бусад судалгаанд хамаарах мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Булган сумын Соёлын төв нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 80 мэдээллийг хугацаанд нь, 69 мэдээллийг хугацаа хоцроосон бол тендер худалдан авах ажиллагаа, 5 сая төгрөгөөс дээш худалдан авсан бараа, ажил үйлчилгээний мэдээлэл, мөнгө зарцуулах 5.1 сая төгрөгийн 11 тушаал, шийдвэрийг байршуулаагүй зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, ххуль журмын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд хэмнэлтийг бий болгоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43-р тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай

хууль тогтоомжийн холбогдох заалтуудтай, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт тус тус бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт, өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг шалгах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 14.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсний 5.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 9.0 сая төгрөгөнд зөвлөмж хүргүүлээ.

Залруулагдаагүй 1 материаллаг алдаа, зөрчлийн дүн 0.2 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 1.7 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залрууллага гараагүй болно.

4.2 Албан шаардлага

Цалингийн зардлаас нэр бүхий 2 ажилтанд 0.2 сая төгрөгийн шагнал олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс үзэхэд 20 нэр төрлийн 9.0 мянган төгрөгийн хөрөнгө элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан байна.

Өгсөн зөвлөмж: Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.3.2 “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэж заасны дагуу арга хэмжээ авч ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
		2	9.2					1	0.2	1	9.0
	дүн	2	9.2					1	0.2	1	9.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
		2	5.1					2	5.1		
	дүн	2	5.1					2	5.1		
	Нийт дүн	4	14.3					3	5.3	1	9.0